

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/016/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням Утас: 329871 Цахим хаяг: <a href="mailto:sambuunyamy@audit.gov.mn">sambuunyamy@audit.gov.mn</a> Санхүү нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Хэлтсийн дарга: Б.Лхагвацэнд Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:khagvatsendb@audit.gov.mn">khagvatsendb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Мягмаржав Утас: 263533 Цахим хаяг: <a href="mailto:myagmarjagt@audit.gov.mn">myagmarjagt@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.4.2 Авлага .....	10
3.4.3 Урьдчилгаа .....	10
3.4.4 Бараа материал .....	11
3.4.5 Үндсэн хөрөнгө .....	11
3.4.6 Өр төлбөр .....	12
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.5.3 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт .....	13
3.5.4 Нэмэлт төсөв.....	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	13
3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төсвийн шууд захирагчид.....	16
5.1.1 Төлбөрийн акт .....	16
5.1.2 Албан шаардлага.....	16
5.1.3 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА

2025.04.25 № 1613  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 01 дугаар тогтоол гарч Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,349.3 сая төгрөгийн балансын үнэтэй, 273.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үл хөдлөх хөрөнгийг Улсын Их Хурлын Тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 130 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэх үйл ажиллагааны зардалд Засгийн газрын нөөц сангаас 6,529.1 сая төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 4,342.2 сая төгрөгийг зарцуулан зарцуулагдаагүй үлдэгдэл 2,186.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан бүсчилсэн форумыг улсын хэмжээнд зохион байгуулахад зориулж Улсын Их Хурлын Тамгын газарт Засгийн газрын нөөц сангаас 1,440.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>6,480,541.3</b>	<b>5,476,190.3</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,082,677.9	3,450,847.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	41,160.2	74,674.0
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	4,274,815.5	893,662.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,081,887.7	1,057,006.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>5,641,902.2</b>	<b>26,505,812.0</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	<b>5,641,902.2</b>	<b>26,505,812.0</b>
39200	Биет хөрөнгө		5,163,757.2	25,118,598.2
39300	Биет бус хөрөнгө		478,145.0	1,387,213.8
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>12,122,443.5</b>	<b>31,982,002.2</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>15,545.7</b>	<b>992,623.6</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	15,545.7	992,623.6
41300	Өглөг	17а, 17б	15,545.7	992,623.6
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>12,106,897.7</b>	<b>30,989,378.7</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>12,106,897.7</b>	<b>30,989,378.7</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал		3,560,849.8	3,560,849.8
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>8,546,048.0</b>	<b>27,428,528.9</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>12,122,443.5</b>	<b>31,982,002.2</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>70,990,970.8</b>	<b>149,637,051.2</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,909,928.6	3,482,772.8
120	Нийтлэг татварын бус орлого	1а, 1б	1,232,948.6	2,779,746.2
122	Тусламжийн орлого		676,980.0	703,026.5
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>69,081,042.2</b>	<b>146,154,278.4</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>69,926,056.7</b>	<b>130,741,200.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		69,636,572.6	125,185,634.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		67,747,510.0	101,821,405.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,732,790.9	41,566,477.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,455,730.0	5,082,562.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,181.8	25,839.4
2104	Хангамж, бараа материалын зардал		942,387.7	2,835,024.6
2105	Нормативд зардал		160.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		55,195.2	466,234.0
2107	Томилолт, зочны зардал		2,970,623.2	4,575,125.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,542,457.7	9,137,501.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		26,032,983.3	38,132,640.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		<b>1,889,062.6</b>	<b>23,364,228.5</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		289,484.0	5,555,566.3
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>1,064,914.1</b>	<b>18,895,850.7</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>84,903.8</b>	<b>13,369.8</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>980,010.2</b>	<b>18,882,481.0</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,126,887.5</b>	<b>11,126,887.5</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,126,887.5	11,126,887.5
9	Тайлант үеийн үр дүн	980,010.2	980,010.2
<b>10</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,106,897.7</b>	<b>12,106,897.7</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,106,897.7	12,106,897.7
19	Тайлант үеийн үр дүн	18,882,481.0	18,882,481.0
<b>20</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>30,989,378.7</b>	<b>30,989,378.7</b>

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>70,002,232.9</b>	<b>149,617,657.5</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>921,190.7</b>	<b>1,127,492.7</b>
120	Нийтлэг татварын бус орлого		244,210.7	561,654.2
122	Тусламжийн орлого		676,980.0	565,838.5
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>69,081,042.2</b>	<b>148,490,164.8</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>71,009,335.0</b>	<b>126,446,958.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>71,009,335.0</b>	<b>126,446,958.2</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		69,120,272.3	100,842,448.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,742,262.1	41,567,895.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,455,730.0	5,083,396.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,181.8	59,187.4
2104	Хангамж, бараа материалын зардал		906,050.1	3,003,638.1
2105	Нормативд зардал		160.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		55,195.2	497,812.4
2107	Томилолт, зочны зардал		2,970,411.8	4,575,125.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,719,806.5	10,028,454.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		24,255,474.6	36,026,939.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,889,062.6	25,604,510.1
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>(1,007,102.0)</b>	<b>23,170,699.4</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>1,949,309.9</b>	<b>20,802,529.6</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,949,309.9	20,802,529.6
2200	Дотоод эх үүсвэрээр		1,949,309.9	20,802,529.6
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>(1,949,309.9)</b>	<b>(20,802,529.6)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		<b>(2,956,412.0)</b>	<b>2,368,169.8</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,039,089.8	1,082,677.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,082,677.9	3,450,847.7

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>142,182,676.8</b>	<b>120,693,541.4</b>	<b>21,489,135.4</b>	<b>84.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>120,093,076.8</b>	<b>99,287,117.7</b>	<b>20,805,959.1</b>	<b>82.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>115,868,907.4</b>	<b>96,165,268.5</b>	<b>19,703,638.9</b>	<b>83.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,584,654.4	41,567,895.3	13,016,759.1	76.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,893,757.7	5,083,396.5	1,810,361.2	73.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,363.7	59,187.4	29,176.3	67.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,709,122.8	3,034,282.7	674,840.1	81.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,860,241.7	1,093,624.4	766,617.3	58.8
2107	Томилолт, зочны зардал	5,345,345.2	4,534,367.0	810,978.2	84.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,406,699.9	10,617,436.7	789,263.2	93.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,980,722.0	30,175,078.5	1,805,643.5	94.4
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,224,169.4</b>	<b>3,121,849.2</b>	<b>1,102,320.2</b>	<b>73.9</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	41,364.0	41,364.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,182,805.4	3,080,485.2	1,102,320.2	73.6
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>22,089,600.0</b>	<b>21,406,423.8</b>	<b>683,176.2</b>	<b>96.9</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>142,182,676.8</b>	<b>121,347,863.0</b>	<b>20,834,813.8</b>	<b>85.3</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>142,082,676.8</b>	<b>120,654,034.0</b>	<b>21,428,642.8</b>	<b>84.9</b>
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>100,000.0</b>	<b>127,990.5</b>	<b>(27,990.5)</b>	<b>128.0</b>
	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>0.0</b>	<b>565,838.5</b>	<b>(565,838.5)</b>	<b>-</b>
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	214,355.8	(214,355.8)	-
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>2100</b>	<b>2070</b>	<b>30.0</b>	<b>98.6</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1049</b>	<b>1034</b>	<b>15.0</b>	<b>98.6</b>
620001	Удирдах ажилтан	130	129	1.0	99.2
620002	Гүйцэтгэх ажилтан	879	865	14.0	98.4
620003	Үйлчлэх ажилтан	40	40	-	100.0
	Үүнээс:				
620002	Ажлын алба	368	368	-	100.0
620002	Улс төр	155	155	-	100.0
620002	Үйлчлэх	511	511	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>8,118,097.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>8,118,097.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>5,851,209.3</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>5,851,209.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,851,209.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>2,266,888.5</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,266,888.5
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,266,888.5
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>8,118,097.9</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>8,118,097.9</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	148,997.9
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,969,100.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 төслийн санхүүгийн тайлан нэгтгэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 14.8 сая төгрөгийн 5 зөрчил илэрч, 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 14.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өгсөн.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### 3.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын их хурлын Тамгын газар	4	14.8	1	0.6	1	14.2	2	-
Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн	1	0	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>14.8</b>	<b>1</b>	<b>0.6</b>	<b>1</b>	<b>14.2</b>	<b>3</b>	<b>-</b>